

4.2 Дэвшилтийн бүртгэл хийх

4.2 Дэвшилтийн бүртгэл хийх

Суралцагчийг дэвшилтийн бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Дэвшилт**-ийг сонгоход дараах цонх нээгдэнэ.

Дэвшилт

Хураах

Хянах самбар

Заавар

Хичээлийн дүн 1082/2838

Дэвшилтийн бүртгэл 58/60

Хөтөлбөр: Суурь боловсролын өдрийн хөтөлбөр /Ердийн/

Анги: 8-р анги

Бүлэг: 8-а

Хичээлийн жил: 2017-18 Хичээлийн жил

Сургалтын хөтөлбөр

Суурь боловсролын өдрийн

Анги: 8-а (1-р ээлж)

№	Суралцагч	Регистр	Бүлэг	Шийдвэр	Шалтгаан	Дэвших анги	Шийдвэр №	Огноо	Төлөв
1			8-а						Бүртгээгүй
2			8-а						Бүртгээгүй
3			8-а						Бүртгээгүй
4			8-а						Бүртгээгүй
5			8-а						Бүртгээгүй
6			8-а						Бүртгээгүй

Дэвшилтийн бүртгэл хийхэд дараах бүртгэлийг хийнэ.

Алхам	Үйл явц	Тайлбар
4.	Суралцагч	Дэвшилтийн бүртгэл хийх суралцагчийг сонгох
5.	Шийдвэр	Уг шийдвэр <ul style="list-style-type: none"> • Дэвшүүлэх – 8-р ангийн суралцагч 9-р ангид дэвшин суралцах төлвийг илэрхийлнэ. • Давтан суралцуулах- 8-р ангийн суралцагч 8-р ангид ахин суралцах төлвийг илэрхийлнэ.
6.	Шалтгаан	Дээрх шийдвэрээс хамаарч шалтгааныг сонгож оруулах боломжтой. <ul style="list-style-type: none"> • Дэвшүүлэх – Бусад, Суралцах түвшин амжилттай • Давтан суралцуулах – дараах сонголтоос хийх боломжтой. <p>Эрүүл мэндийн шалтгаанаар</p> <p>Сурлагын амжилт хангалтгүй</p> <p>Хичээл дутуу судалсан</p> <p>Шалгалт өгөөгүй(Төгсөх эсвэл дэвших)</p> <p>Ирэхээ больсон</p> <p>Гэмт хэрэгт холбогдсон</p> <p>Амьдралын шаардлагаар</p>
7.	Шийдвэрийн №	Уг дэвшүүлэх болон давтан суралцах шийдвэр гарсан бол шийдвэрийн дугаарыг оруулна уу.
8.	Огноо	Дэвшилтийн бүртгэл хийсэн огноог оруулж өгнө үү.
9.	Төлөв	<ul style="list-style-type: none"> • Бүртгээгүй – Дэвшилтийн бүртгэл хийх үйлдэл хийгдээгүй суралцагчийн дээрх төлөвтэй байна. • Бүртгүүлсэн – Дэвшилтийн бүртгэл хийгээд хадгалсан бол уг төлөвт шилжинэ • Дэвшсэн – Суралцагчийн дэвшилт хийх бүртгэлийг Сургалтын менежер баталгаажуулсан бол дээрх төлөвт шилжинэ. • Давтан – Суралцагчийг давтан суралцуулахаар шийдвэр гарсан төлөв.
10.	Хадгалах	Нийт суралцагчдын дэвшилт, давтан суралцуулах шийдвэр гарч бүртгэлийг хийсэн бол Хадгалах товч дарсан үед сургалтын менежер баталгаажуулах боломжтой болно.